

**ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-11</i>

1. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	3-11
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 04 дүгээр
сарын 16-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны
товч тэмдэглэл**

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 17 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан;

Чөлөөтэй: С.Бямбацогт.

Нэг. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн Л.Цэдэвсүрэн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Б.Пүрэвдагва, мөн зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Ёс зүйн хорооны гишүүн Д.Дуламсүрэн, М.Цэрэнбат, мөн хорооны Ажлын албаны Захиргаа, эрх зүйн хэлтсийн дарга З.Цэдэнжав, Монгол Улсын Их сургуулийн Нийтийн удирдлагын сургуулийн тэнхимийн ахлах багш Г.Мягмар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт С.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн талаар Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Ёс зүйн хорооны гишүүн Д.Дуламсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Баттөмөр, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Н.Энхболд нар үг хэлэв.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн 1.2.4.Ёс зүйн зөрчил гаргаж төрийн албанаас халагдсан, сайн дураараа төрийн албанаас чөлөөлөгдсөн этгээдийг дахин төрийн албанд ажиллуулахгүй байх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2.6.Сонгуулийн төв байгууллага бүх шатны сонгуульд нэр дэвшигчид ёс зүйн мэдүүлэг гаргуулах эсэх асуудлыг судалж, шийдвэрлүүлнэ гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Баттөмөр: “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 33 минут үргэлжилж, 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
11 цаг 17 минут

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баттөмөр: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгаж мэндчилье.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 24 оны 04 дүгээр сарын 16-ны хуралдаан нээснийг мэдэгдье.

Ирцийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу Баагаагийн Баттөмөр байна. Адьшаа гишүүн томилолттой явж байгаа юм байна. Баделхан гишүүн байна. Бат-Эрдэнэ гишүүн томилолттой явж байгаа юм байна. Баярсайхан гишүүн томилолттой. Бейсен гишүүн байна. Бямбацогт гишүүн ирэх байх. Баттөмөрийн Энхбаяр гишүүн байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн байна. Нямаагийн Энхболд гишүүн байна.

Ингээд хуралдаан 60 хувийн ирцтэй байна. Хуралдааны ирц бүрдсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, үндэсний хөтөлбөр батлах тухай” Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэх.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Амартөгс Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга, Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн, Баатарсайхан Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Пүрэвдагва Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Дуламсүрэн Ёс зүйн хорооны гишүүн, Цэрэнбат Ёс зүйн хорооны гишүүн, Эрдэнэчимэг Ёс зүйн хорооны гишүүн, Бат-Эрдэнэ Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга, Цэдэнжав Ёс зүйн хорооны ажлын алба, Захиргааны хэлтсийн дарга, Мягмар МУИС-ийн Нийтийн удирдлагын танхимын ахлах багш гэсэн ийм бүрэлдэхүүнтэй хүмүүс ирсэн байна.

Тогтоолын төслийн танилцуулгыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Амартөгс хийнэ. Амартөгс гишүүнд микрофон өгье. 1 номерын микрофон өгье, номерын микрофон өгье ажиллаж байна.

Ц.Амартөгс: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 онд батлагдаж, хэрэгжиж эхлээд байгаа. Улсын Их Хурлын даргын 2023 оны 209 дүгээр захирамжаар Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баттөмөр даргаар ахлуулан байгуулж ажиллуулсан.

Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөл, Улсын Их Хурлын Тамгын газар, ХЭҮК, ЗГХЭГ, Эдийн засгийн хөгжлийн яам, ХЗДХЯ, БШУЯ, МУИС, Удирдлагын академи, ШУА-ийн Философийн хүрээлэн зэрэг

байгууллагуудын төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулаа.

Ажлын дэд хэсгээс боловсруулсан хөтөлбөрийн төслийг олон нийтээс санал авах хүрээнд Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас Ди парламент платформд нийтэлж нээлттэй санал авсан. Мөн Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 цахим хэлэлцүүлгээр 2800 гаруй төрийн албан хаагчийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Мөн танхимын хэлбэрээр 7 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг төрийн болон ТББ иргэдийн оролцоотой зохион байгуулаад албан ёсоор 45 байгууллагын болон иргэд иргэний нийгмийн байгууллагаас ирүүлсэн 520 гаруй саналыг нэгтгэн боловсруулаа. Мөн ажлын хэсгийн ахлагч болон ажлын хэсэгт танилцуулж, санал зөвлөмжийн дагуу нэгтгэн боловсруулсан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн үндсэн зорилго, зарчмын хүрээнд тогтоосон хэм хэмжээ, шаардлага, хориглох зүйлийн хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, мөн цахим мэдээллийн сан үүсгэх, тайлагнах, иргэдэд ил тод мэдээлдэг байх, Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үндсэн зохицуулалтуудыг хамран зохицуулагдаж байгаа.

Хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад холбогдох бодлого, эрх зүйн баримт бичгийг үндэслэсэн.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн зарчмын хүрээнд олон улсын байгууллагууд, НҮБ, Дэлхийн банк, Эдийн

засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Трансперенси интернэшнл зэрэг төрийн бус байгууллагуудын гаргасан баримт бичиг, аргачлал, заавар зэргийг харьцуулж үзээд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын ethical infrastructure буюу этикийн дэд бүтцийн ёс зүйн менежментийн цогц стратегид суурилан энэхүү хөтөлбөрийн агуулгыг томъёолсон. Түүнчлэн Австрали, Англи, Хонконг, Сингапур, Бүгд Найрамдах Солонгос улс, Япон, Швед, Норвег, Дани, АНУ, Канад зэрэг улсуудын ёс зүйн менежмент, хууль тогтоомж, стратеги бодлогоо хэрэгжүүлж байгаа туршилагыг харгалзан үзсэн.

Мөн төрийн албанд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хийгдэж байгаа үйл ажиллагааны арга хэрэгслүүдийг судлан Монгол Улсад хэрэгжих нөхцөл байдалтай уялдуулан боломжтой гэж тодорхойлогдсон зорилт, үйл ажиллагааг тусгасан байгаа.

Мөн дотоодын эрдэмтэн, судлаачдын сүүлийн үед хийсэн судалгаануудын үр дүнг харьцуулан үзсэн. Тухайлбал, төрийн албаны үнэт зүйл, тулгамдаж байгаа асуудлууд, төрийн захиргааны албаны ёс зүйн хариуцлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ зэрэг судалгааны үр дүнгээс харах юм бол ёс зүйн зөрчил гаргасан нөхцөлд хариуцлага тооцох механизм сул байна.

Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл нь зөвхөн сургалт зохион байгуулах төдийд хэрэгжиж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг мэдээлэх, хянан шийдвэрлэх, зөрчлөөс сэргийлэх тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажилласан эсэхийг харгалзан үздэггүй. Албан тушаал дэвшүүлэх, шагнах,

урамиуулахдаа чадахуйн зарчмыг мөрдөх механизм бүрдээгүй байна зэрэг энэ асуудлууд дээр төвлөрч энэхүү хөтөлбөрийн шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлсон.

Өнөөдрийн байдлыг харж үзвэл өмнөх онд 2961 Ёс зүйн зөвлөлүүд байгуулаад ажиллаж байсан. Шинэ хуулийн хүрээнд Ёс зүйн дэд хороод байгуулагдан ажиллахаар байгаа. 2024 оны 2 дугаар сарын байдлаар гэхэд 2040 байгууллагын дэргэдэх дэд хороо байгуулагдаад, 8600 орчим төрийн албан хаагчид энд ажиллаж эхлээд байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг 4 зорилго, түүний хүрээнд 11 зорилт, 57 үйл ажиллагаа байхаар боловсрууллаа. Үүнд:

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдамж заавраар хангаж зохион байгуулалтыг сайжруулах.

2.Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих, сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны эрчимжүүлэх,

3 дугаарт, удирдлага зохион байгуулалттай холбоотой буюу ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулах,

4 дүгээрт, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын түншлэлийг сайжруулах, оролцоог хангах зорилгыг тодорхойлсон болно.

Мөн хөтөлбөрийг батлах Улсын Их Хурлын тогтоолын төсөлд 4 заалттай байхаар боловсруулсан. Үүнд:

Үндэсний хөтөлбөрийг батлах, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих зохицуулалтыг тусгасан. Ялангуяа бүх шатын төрийн байгууллагууд, Ёс зүйн

хороо, дэд хороо, үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхдээ салбар нэгжийн онцлогт нийцүүлэн жил бүр үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаж, хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны хөтөлбөр, үндсэн чиглэл, төсөвт тусган хэрэгжилтийг зохион байгуулахаар заалаа.

Энэхүү үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагаа дараах ахиц үр дүн гарна гэж үзсэн. Төрийн албаны хүний нөөцийг ёс зүйтэй иргэдээр бүрдүүлэх, эрсдэлд суурилсан үнэлгээ тогтмол хийж, албан хаагчийн ёс зүйн зөрчил хариуцлагын мэдээллийн хуудсыг хэвшүүлэх, төрийн өндөр болон томилох эрх бүхий албан тушаалтнуудын ёс зүйн манлайлалыг төлөвшүүлж, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, Ёс зүйн дэд хороодын үүргийг үе шаттайгаар нэмэгдүүлэх замаар ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний нэг саллигүй хэсэг болгон үнэлэх тогтолцоог боловсронгуй болгох ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёлыг хэвшүүлэх, ёс зүйн алдаа гаргасан албан тушаалтан ажлаасаа чөлөөлөгддөг байх хандлага, ёс зүйг төлөвшүүлэх, төр төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд ноогдуулсан хариуцлагыг түүний хяналтын бүртгэлийн системийг бий болгоод олон нийт, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагааг нэмэгдүүлэх. Түүнчлэн төрийн албанд ёс зүйн хууль тогтоомж, хэм хэмжээг дагаж мөрдөх тогтолцоо бий болсноор энэ хөтөлбөр хэрэгжсэнээр ёс зүйн зөрчлийг шалган шийдвэрлэх чадавх бэхжиж, олон нийтийн оролцоо, хяналт сайжирна гэж үзсэн.

Энэхүү төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг батлах Улсын Их Хурлын тогтоолын

төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон Хууль тогтоомжийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль зэрэг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9.2-т заасныг үндэслэн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг батлах Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Үндэсний хөтөлбөрийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгын хамтаар ажлын хэсгийн өгсөн зөвлөмж, саналыг тусган эцэслэн боловсруулсан болно. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

Б.Баттөмөр: Амартөгс даргад баярлалаа.

Тогтоолын төслийг бол цахим хэлбэрээр тараасан байгаа, бичгээр тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Энхбаяр гишүүнээр тасалъя. Баделхан гишүүн асуултаа асууя.

Х.Баделхан: Баярлалаа. Энэ ажлын хэсэгт ороод ажилласан, хөтөлбөрийг бол ерөнхийдөө дэмжиж байгаа. Ер нь төрийн ажил л шуурхай байх ёстой л доо. Ямарваа нэг улсын нэр хүнд бол ерөөсөө төрийн нэр хүнд бол төрийн албан хаагч нараас л шалтгаалдаг. Тэгээд хамгийн гол нь энэ дунд шатдаа төрийн ажил бол маш шуурхай байх ёстой. Үүнийг ерөөсөө шуурхай болгох ганцхан арга зам бол энд цахимжуулах, улсын хэмжээнд. Тэгэхээр ер нь төрийн албаны үйлчилгээний ажил ер нь хэчнээн төрлийн ажил байдаг юм.

Яг өнөөдрийн байдлаар цахимжсан, тэгээд энэ талаар цаашидаа ямар бодлого баримталж байгаа юм. Ерөөсөө цахимжсан нөхцөлд л энэ чинь

шударга болоод ямар нэг арын хаалга, ар өврийн хаалга байхгүй шударга л болно л доо. Энэ тал дээр бол амжилт гарч байгаа салбарууд байгаа. Энэ тал дээр цаашидаа энэ хөтөлбөрт орсон зүйл байна уу.

Ер нь яаж хэрэгжих вэ, ямар шатдаа байна гэсэн ийм л асуулт байна. Баярлалаа.

Б.Баттөмөр: Хэн хариулах вэ? Амартөгс 1 номерын микрофоныг өгье. Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Амартөгс.

Ц.Амартөгс: Гишүүний асуултад хариулъя. Цахимжуулах үйл ажиллагаа нэлээн олон хүрээнд хийгдэж байгаа. Төрийн байгууллагууд бүх үйл ажиллагаагаа цахимжуулах алхмуудыг бодлого зохицуулалтынх нь хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам дээр бодлого зохицуулалтыг нь нэгтгээд, салбарын байгууллагуудын үйлчилгээний цахимжилт бол хийгдэж байна. Төрийн албаны албан хаагчийн үйл ажиллагаа, үр дүнг ил тод мэдээлдэг байх, мөн үйл ажиллагааны үр дүнтэй холбоотойгоос гадна сахилга, ёс зүйн хариуцлага тооцсон байдалтай холбоотой цахим системийг бүрдүүлэх энэ ажил энэ хөтөлбөрийн төсөлд тусгагдсан. Энэ маань одоогоор суурь нь бүрдээд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа, хүний нөөцийн удирдлага, мэдээллийн цахим систем дотор орсон. Нийт төрийн албан хаагчид, төрийн байгууллагуудын хүрээнд энэ ажлууд бол хийгдэж байгаа. Одоогоор 4239 байгууллагын 226496 төрийн албан хаагч энэ цахим системд бүртгэлтэй. Энэ бүртгэл дээр үндэслээд тухайн албан хаагчийн хөдөлмөр эрхлэлтийн түүх мөн урамуулал, шагнал, шийтгэлийн тухай мэдээллүүд тус бүрдээ модуль болгон хөгжөөд үйл ажиллагаанд ашиглагдаж явж байна.

Одоо энэ хөтөлбөрт тусгагдсан цахим систем, ёс зүйн хариуцлага, зөрчлийн бүртгэл гэдэг энэ хэсэг бол яг

энэ системтэй уялдаатайгаар хөгжүүлэгдэх, ашиглагдах ийм систем байгаа гэдгийг хэлье.

Б.Баттөмөр: Ёс зүйн байнгын хорооны гишүүн, ХЗДХ-ийн сайд Энхбаяр асуулт асууна.

Б.Энхбаяр: Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг зарчмын хувьд дэмжиж байгаа. 3 асуулт байна.

1-д, энэ төрийн албан хаагч гэдгийгээ бол зөвхөн төрийн захиргааны болон тусгай албан хаагчийн хүрээнд авч үзэж байна уу, эсвэл ерөөсөө төрийн улс төрийн албан тушаалтан бас орж байна уу гэсэн эхний асуулт байна.

2 дахь асуулт нь энэтэй холбоотойгоор хөтөлбөрийн 1.2.4-д сайн дураараа төрийн албанаас чөлөөлөгдсөн этгээдийг дахин төрийн албанд ажиллуулахгүй байх бодлогыг хэрэгжүүлнэ гэдэг дээр асуулт байна. Өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөх чинь хэд хэдэн үндэслэл байгаа шүү дээ. 3 үндэслэл байгаа шиг санаж байна, Төрийн албаны хуульд зааснаар.

Тэгэхээр өөрөө хүсэлтээрээ хүн чөлөөлөгдөх энэ чинь эрхтэй шүү дээ. Энэ нь бол би янз бүрийн шалтгаан байж болно. Эрүүл мэндийн шалтгаан байж болно. Сургалтын 3 сараас дээш сургалтын чөлөө байж болно. Тэгээд өөрөө ингээд чөлөөлөгдсөн хүнийг дахин төрийн албанд ажиллуулахгүй гэдэг нь энэ ямар бодлого ороод ирэв ээ? Би бол үүнийг бол шууд дэмжихгүй байна. Хуультай нийцэхгүй байна, хүний эрхийг зөрчиж байна гэж үзэж байна.

1.2.6-д байгаа сонгуулийн төв байгууллага бүх шатын сонгуульд нэр дэвшигчид ёс зүйн мэдүүлэг гаргах асуудлыг судалж шийдвэрлүүлнэ гэж. Би яагаад эхний асуултыг тэгж асуусан бэ

гэхээр ёс зүй бол улс төрийн ёс зүй гэж байдаг. Мөн төрийн жинхэнэ албаны тухайд ёс зүй, тэр дотроо төрийн тусгай албан тушаалтны ёс зүй бол бас өөр өөр тавигддаг. Жишээлбэл, тусгай алба буюу мөрдөстэй байгууллагуудад тавигддаг шаардлага бол дээд шатын удирдах албан тушаалтны хууль ёсны тушаалыг шууд хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл захирах, захирагдах ёс тэнд хатуу үйлчилдэг. Мэдлээ, гүйцэтгээ гэдэг командаар ажилладаг. Тэгтэл захиргааны албан тушаалтны тухайтад бол энэ мөрдөстэй байгууллагуудаас арай өөр шаардлага тавигддаг. Улс төрийн албан тушаалтны хувьд бол бүр өөр. Энэ өөр өөрийн онцлог шаардлагууд байдаг л даа.

Тэгэхээр энэ Сонгуулийн ерөнхий хороо бүх шатын сонгуульд нэр дэвшигчид ер нь ёс зүйтэй эсэх гээд ингээд чамайг нэр дэвшүүлэхийг чинь би мэднэ гээд суучих юм уу? Энэ ард түмний сонгох, сонгогдох эрхэд дундаас нь яагаад Сонгуулийн ерөнхий хороо оролцох гээд байгаа юм. Чи ёс зүйтэй, чи ёс зүйгүй учраас чи нэр дэвшихгүй гэж хэлдэг этгээд бол Сонгуулийн ерөнхий хороо биш. Үүнийг бол ард түмэн өөрөө шийднэ.

Тийм учраас энэ Үндсэн хуульд заасан сонгох, сонгогдох эрх рүү орж ирж байгаагийн үндэслэл, шалтгаан яг юу байгаа юм бэ? Энэ эрх барьж байгаа нам юм уу, эсвэл Сонгуулийн ерөнхий хороо олонх бүрдүүлж байгаа нам, сөрөг хүчин юм уу, цөөнхийгөө ёс зүйтэй, ёс зүйгүйгээр нь үнэлээд нэр дэвших эсэхийг нь шийдээд суух гэж байгаа бол энэ хэрхэвч байж таарахгүй.

Тийм учраас энэ бол Сонгуулийн ерөнхий хороо болон Төрийн албаны зөвлөлийн оролцох харилцаа биш байна гэж би хэлэх гэж байгаа юм. Яг энэ үндэслэлээр. Тэгэхээр энэ дээр би асуулт асуучихъя.

Б.Баттөмөр: Хэн хариулах вэ?
Амартөгс 1 номерын микрофон.

Ц.Амартөгс: Эхний асуултад хариулъя. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн маань үйлчлэх хүрээ өргөн байгаа. Төрийн албаны тухай хуульд заасан 4 төрлийн албан хаагчид төрийн тусгай албан хаагч, төрийн захиргааны албан хаагч, төрийн улс төрийн албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчаас гадна Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.7, 4.1.9 гээд яг төрийн өмчит үйлдвэрийн газар, ОНӨҮГ-ын зөвхөн удирдах албан хаагчдын асуудлууд энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн үйлчлэлд хамарч байгаа.

Тэгэхээр энэ хүрээнд нь хуулийн үйлчлэл бүрэн үйлчлэлийнх нь хүрээнд үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт тодорхойлогдож явж байгаа. Ойролцоогоор төрийн албан хаагчийн 226496 албан хаагчаас гадна Авлигын эсрэг хуулийн 9046 орчим албан хаагч энд заасан этгээд хамрах юм байна гэдэг ийм тооцоолол урьдчилсан байдлаар гаргасан байгаа. Энэ хуулийнхаа үйлчлэлийн хүрээнд. Тэгэхээр хөтөлбөрийн хамрах хүрээ хуулийн үйлчлэх хүрээтэй адилхан гэж тооцсон.

Дараагийн асуултад Дуламсүрэн дарга хариулна.

Б.Баттөмөр: 3 номерын микрофон Дуламсүрэн хариулъя. 2 номерын микрофон.

Д.Дуламсүрэн: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Энэ ёс зүйн зөрчил гаргаж төрийн албанаас халагдсан бол, эс үгүй бол сайн дураараа төрийн албанаас чөлөөлөгдсөн бол тухайн этгээдийг дахин төрийн албанд ажиллуулахгүй байх ийм бодлогыг цаашид баримталъя гэсэн ийм саналыг бол ажлын хэсгийн гишүүдээс гаргаад, тэгээд томъёолж бид нар бас дэмжээд оруулсан байгаа.

Учир нь гэхээр ер нь Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг дээр бол энэ ёс зүйн зөрчил гаргасан бол сайн дураараа ажлаасаа чөлөөлөгддөг байх ийм ёс зүйн соёлыг төлөвшүүлнэ гээд тунхагласан байгаа.

Тэгэхээр нэгэнт ёс зүйн алдаа зөрчил гаргасан бол тэр хүмүүс ажлаасаа чөлөөлөгдөж байна. Ийм учраас ёс зүйн зөрчил гаргасан хүн, ер нь бол ёс зүйн асуудал бол тухайн хүний өөрийнх нь ёс суртахууны төлөвшилтэй шууд холбоотой асуудал учраас ямар нэг хайхрамж болгоомжгүйн байдлаас ёс зүйн алдаа гаргах гэсэн асуудал бол ер нь тун ховор гэж ингэж үздэг.

Тийм учраас ёс зүйн алдаа гаргасан хүний өөрийнх нь ёс зүйн төлөвшил түүнээс илүү өөрчлөгдөх боломж нөхцөл бол ер нь магадлалаас доогуур, 50-аас доошоо хувьтай байдаг гэж үзээд дахиж төрийн албанд ажиллах тохиолдолд ёс зүйн зөрчил дахиад л давтан гаргаад байх ийм нөхцөл байдал бол улмаар үүснэ.

Тэгээд энэ үндэсний хөтөлбөрийн үндсэн концепцын нэг хэсэг нь бол ёс суртахуунтай иргэдээр төрийн албаны хүний нөөцийг сэлбэж, бэхжүүлж явах ийм тогтолцоог бүрдүүлж байгаа учраас ийм бодлогыг цаашид бол ер нь хэрэгжүүлэх нь зөв юм. Одоогийн 1, 2 жил гэснээс илүүтэй 30 он хүртэл бас нөхцөл байдал өөрчлөгдөх байх. Ийм бодлогыг хэрэгжүүлэхийн өмнө мэдээж бодлогын түвшинд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой ийм чиглэлийн зохицуулалтыг бий болгохтой холбоотой суурь судалгаануудыг хийгээд үнэхээр энэ боломжтой байна гэж үзсэн тохиолдолд үүнийг ишийдвэрлэх ийм юмнууд байгаа.

Тийм учраас энэ бодлого боловсруулж хэрэгжүүлэхтэй холбоотой энэ нөхцөл байдлыг судлаад шаардлагатай бол хууль тогтоомжид тусгавал зүгээр юм уу гэсэн байдлаар бас

томъёолж болох юм уу гэж харж байна. Тэгэхдээ яах вэ, хүний эрхийн зөрчлийн хувьд бол яах вэ, байгаа л даа. Яах вэ, нөгөө авлигын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд төрийн жинхэнэ албанд угаасаа ажиллуулдаггүй Төрийн албаны хуулийн үндсэн зарчим байж байна.

Тэгээд авлигын гэмт хэргийн асуудал зөвхөн төрийн албанд авч ажиллуулахгүй гээд байхад ёс зүйн зөрчил төдийхөн гаргачхаад байхад төрийн албанд ажиллуулахгүй байх нь бас зохимжгүй. Хүний эрх зөрчиж байна гэсэн асуудлууд бол ажлын хэсэг дээр бас яригдаж өрнөж хэлэлцүүлэг болж явсан. Гэсэн хэдий ч гэсэн ер нь цаашид энэ асуудлыг бид нар нэгэнт л ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлж, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх гэж л байгаа юм бол бас сайн дураар нэгэнт би төрд ажиллахгүй ээ гээд яваад өгчихсөн, тэгээд ёс зүйн зөрчил бол нэг удаа гаргаад л төрийн албанаас болж халагдах асуудал бас яригдахгүй л дээ. Удаа дараагийн, тэгээд ноцтой хохирол учруулсантай холбоотой асуудал энэ тэр яригдаад явбал яасан юм бэ гэсэн байдлаар тусгасан юм.

3 дахь асуудлын хувьд бол Сонгуулийн төв байгууллага бүх шатын сонгуульд нэр дэвшигчид ёс зүйн мэдүүлэг гаргуулах эсэх асуудлыг судалж шийдвэрлүүлье гэж байгаа юм. Энэ бол нөгөө сонгуулийн төв байгууллагын хувьд бүх шатын сонгуульд нэр дэвшигчдээс тухайн хүний хөрөнгө орлогын мэдүүлгийг бол гаргаж авах ажлуудыг хэвшүүлчихсэн байгаа. Үүнтэй адилхан бас ёс зүйн хувьд бол би төрийн албанд ороод улс улс төрийн албанд ч хамаагүй орсон тохиолдолд бас ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх ийм төлөвшилтэй, юутай гэсэн ийм нэг алга дарам цаасан дээр бас тодорхой асуудлууд асуултууд тавиад тэнд нь хариулуулах байдлаар ийм мэдүүлэг гаргуулбал яасан юм бэ? Эргээд тэр хүн хэдийгээр шууд төрийн албанд томилогдохгүй ч гэсэн нэгэнт төрийн

албаны эгнээнд манлайлж явах хүмүүсийн тоонд орж ирэх учраас энэ хүмүүс хамгийн ёс зүйтэй хүн ... /минут дуусав/

Б.Баттөмөр: Энхбаяр гишүүн тодруулъя.

Б.Энхбаяр: Тэгэхээр Улсын Их Хурлын тогтоол бол хуульд нийцэж гарах ёстой, хуулийнхаа хүрээ рамдаа гарах ёстой, хуулийнхаа хэм хэмжээнээс давж болохгүй. Манай төрийн албаны хэрвээ ийм шаардлага тавих гэж байгаа бол бид Төрийн албаны хуульдаа өөрчлөлт оруулж байж л энэ асуудлыг шийдэх ёстой. Түүнээс биш өөрийнхөө хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдсөн хүнийг дахин төрийн албанд ажиллуулахгүй гээд тогтоолоор бид шийдэж болохгүй. Энэ бол хуулиасаа давна гэсэн үг.

2 дугаарт, энэ зарчим өөрөө зөв юм уу, буруу юм уу. Бид нар энэ гэмт хэргийн тухай яриагүй байгаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл, ажлын байр дээрээ зөв зохисгүй хувцаслачихсан, 1 цаг ажлаасаа хоцорчихсон хүнийг яриад байгаа байхгүй юу. Дотоод журмаа зөрччихсөн. Тэгээд үүнийг бүхэлд нь дахиад төрд ажиллуулахгүй гээд ингэчих юм бол энэ нугалаа гарна. Төрийн албан хаагчдыг энэ ажлын байрны ... /минут дуусав/

Б.Баттөмөр: Энхбаяр гишүүнд нэмж өгье, хугацааг нэмье.

Б.Энхбаяр: Ажлын байрны дарамтад учруулна. Бид нар төрийн жинхэнэ албан хаагчдаа 2 хүчин зүйлээс хамгаалах ёстой. Нэг талаас хууль зүйн хамгаалалтыг бий болгох ёстой, нөгөө талаасаа даргын дур зоргын үзэмжээр төрийн жинхэнэ албан хаагчийг нөлөөлөлдөө оруулах, дарамтаас хамгаалах ёстой. Тэр жинхэнэ албан хаагчид ёс зүйгүй байгаад байна уу, дарга ёс зүйгүй байгаад байна уу. Ёс зүйгүй дарга бол тэр ажлаа хийж байгаа

төрийн албан хаагчийг ийм шалтгаанаар дарамтад учруулна. Өөрөө нөлөөлөлдөө оруулна, зүй бус шаардлага тавина.

Хэрвээ ингээд байх юм бол чамайг 10 минут хоцорсон гэдгээр чинь шалтаглаж байгаад төрийн албанд дахиж ажиллуулахгүй байх ийм хэзэр юм уу ийм бодлогыг тэр хүнд олгож болохгүй. Үүнийг чинь буруугаар ашиглана. Бид нар дарга нарынхаа ёс зүйн асуудлыг шийдэж чадаагүй байж байж, тийм дарга нарт төрийн жинхэнэ албан хаагчдыг өөрийн дур зорго, үзэмжээр халах, солих, зүй бус шаардлага тавих ийм зэвсэг атгуулж болохгүй.

Тийм учраас би энэ 1.2.4-тэй холбоотой асуудал дээр бол хасах саналтай байна.

Б.Баттөмөр: Би бас яг Энхбаяр гишүүнтэй адилхан санал хэлсэн шүү дээ, тийм ээ. Тийм ээ. Тэгээд хүн алдаа гаргаж болдог, алдаагаа засна. Алдаа гаргадаггүй хүн гэж байхгүй шүү дээ, 1 дүгээрт.

2 дугаарт, сайн дураараа төрийн албанаас чөлөөлөгдсөн хүнд ямар нэгэн шалтгаан байж болно шүү дээ, тийм ээ. Өвчилсөн байж болно, албан ажил нь бас өөрт нь таарахгүй, мэдлэг хүрэхгүй ч юм уу. Одоо ямар нэгэн байдлаар би больё гэнгүүт л чи тэндээс чөлөөлөгдсөн байна, больё гээд. Үүнийг би ер нь больё гэсэн шүү дээ. Та нар тэгээд л буцаад л оруулаад ирээд байгаа байхгүй юу. Больчихвол яасан юм. Та нар юу гэж бодож байна. Энэ дээд талын 1.4-ийг. Энэ доод талд нь бол яах вэ дээ, судалж шийднэ гэж байгаа юм. Тэр Их Хуралд дэвшиж байгаа хүмүүс нь энэ 24 оны сонгуульд бол байхгүй. 28 он хүртэл үүнийгээ судлаад, үзээд, хараад тэгээд ямар юм байдаг юм. Хялбаршуулсан байдлаар. Уг нь Улсын Их Хуралд бас ёс зүйтэй хүмүүс сонгогдож байх ёстой л доо.

Энэ 1.4 дээр ер нь хасвал яасан юм бэ. Энэ ер нь хэрэгтэй юу? Та нар ямар саналтай байна? Санал хураагаад хасчих уу.

Энхболд гишүүн.

Н.Энхболд: Энэ манай хөтөлбөр дотор 1 заалт байгаа. Би түүнийг их чухал гэж бодоод байгаа. Нөгөө төрийн албан хаагчдад ёс зүйн хувийн хэрэг дээр нь бүртгэл явуулдаг, тийм ээ. Тэгээд л түүн дээр нь тэмдэглээд л, тэмдэглээд л яваад байх нь яг тэр ажиллаж байгаа газруудынх нь үүрэг байх. Түүнийг дараа нь жишээ нь Их Хуралд дэвшинэ үү, эс үгүй бол өөр ямар нэгэн ажилд очно уу, дахиад төрийн албанд орно уу, тэр үед нь чи урьд нь энд хааж байсан юм байна, тэр нөгөө бүртгэл дээр чинь ямар байна гэдгийг нь үзээд, тэгээд тэр авч байгаа газрууд нь эс үгүй бол дэвшүүлж байгаа газрууд нь шийдээд явдаг ийм зарчмаа барьчихвал нэг их олон, жишээ нь Энхбаяр сайдын яриад байгаа тэр зарчмууд хадгалагдаж үлдээд, авч байгаа газрууд нь өөрсдөө энэ ч дээ, тийм ээ, түүнээс автоматаар шууд тэглээ гээд хасдаг гээд оруулчихвал бас нэг арай жсоохон нээрээ зохимжгүй ч юм уу л гэж бодогдлоо шүү. Түүнийг нь л бүртгээд сайн яваад байвал би жишээ нь байгууллагын дарга байж байгаад 1 хүн авна гэвэл чи нөгөө бүртгэлээ аваад тэр эс үгүй бол нөгөө юунаасаа цахим сангаасаа гаргаад үзчихнэ шүү дээ. Энэ нөхөр чинь ингэж, ингэж байсан юм байна. Ажилд нэг 10 минут хоцорсны төлөө ч ирэх биш яахгүй л байх л даа. Ер нь энэ чинь яах ч аргагүй л ёс зүйн зөрчил гаргаж байсан хүн байна даа гэдгийг нь үзээд, тэгээд авах авахгүйг нь өөрсдөө шийддэг тэр юмыг нь нээлттэй орхичихвол илүү тохиромжтой юм болов уу л гэж бодоод байна.

Б.Баттөмөр: Энхбаяр сайд зарчмын зөрөөтэй саналын томьёолол яасан байна. Хөтөлбөрийн 1.2.4, 1.2.6-г хасъя гэсэн саналтай байна. 1.2.4 нөгөө

сая нөгөө төрийн албанд авахгүй, нөгөөдөх нь нэг сонгуулийн юм байна.

Үүнийг 1.2.4 ёс зүйн зөрчил гаргаж халагдсан хүнийг төрийн албанд ажиллуулахгүй, 1.2.6 сонгуулийн төв байгууллага бүх шатны сонгуульд нэр дэвшигчид ёс зүйн мэдүүлэг гаргах асуудлыг судалж шийдэх гээд энэ 2-ыг хасчихъя гэж хасчихвал яадаг юм.

Энэ 2 заалтыг хасъя гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя.

66,7 хувийн саналаар Энхбаяр сайдын санал дэмжигдлээ. Энэ хөтөлбөрөөс энэ 2 заалтыг хасъя гэж.

Ингээд дараагийн асуудал бол юу гэхээр энэ цахимаар тараачихсан байгаа хөтөлбөрүүдийг. Тийм учраас асуулт асуугаад үг хэлчихсэн. Тийм ээ.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлж дууслаа. Санал хураалт сая зарчмын зөрөөтэй санал хураалт явуулчихлаа.

Одоо санал хураалт явуулъя.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 66,7 хувь нь дэмжиж байна.

Тэгээд энэ Улсын Их Хурлын тогтоолын төсөл соён гэгээрүүлэх хөтөлбөрийнхөө үг үсгийн алдаануудыг дахиж нэг нягталж хянаад, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд оруулж танилцуулъя.

Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд танилцуулах гишүүнийг томилъё. Баделхан гишүүн танилцуулчихъя.

Би танилцуулъя, тэгвэл.

11.50 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ